
www.kwu.ac.kr

Солонгос хэлний курсд Гадаад оюутан элсүүлэх 2023оны танилцуулга



Гванжу Эмэгтэйчүүдийн Их Сургууль

KWANGJU WOMEN'S UNIVERSITY

2023
Admission Guidelines of
Korean Language Course for
International Student

Гарчиг

[Солонгос хэлний курсын элсэлтийн танилцуулга]

I | Тавигдах шаардлага 4
II | Сургалтын төлөвлөгөө 4
III | Элсэлтийн хариу танилцуулах 5
IV | Бүрдүүлэх материал 5
V | Сургалтын төлбөр болон тэтгэлэг 6
VI | Дотуур байр 6

[Баклаврын зэрэгт гадаад оюутан элсүүлэх танилцуулга]

I | Тавигдах шаардлага 7
II | Бүртгэл авах анги 8
III | Танхимын танилцуулга 9
IV | Бүрдүүлэх бичиг баримтууд 12
V | Сонгон шалгаруулалтын танилцуулга 13
VI | Сургалтын төлбөр болон тэтгэлэг 13

[Магистрын зэрэгт гадаад оюутан элсүүлэх танилцуулга]

I | Тавигдах шаардлага 15
II | Бүртгэл авах анги 15
III | Сонгон шалгаруулалтын танилцуулга 16
IV | Сургалтын төлбөр болон тэтгэлэг 16
V | Мэргэжлийн танилцуулга 17

[Элсэгчийн анхаарах зүйлс, Хотхоны газрын зураг] 19

[Холбоо барих] 20

KWANGJU **WOMEN'S** UNIVERSITY





Гванжу Эмэгтэйчүүдийн Их Сургуулийн Солонгос хэлний бэлтгэлд гадаад оюутан элсүүлэх 2023оны танилцуулга



· Байршил: Gwangsan-gu, Gwangju, Korea
· Ангилал: 4жилийн сургалттай хувийн эмэгтэйчүүдийн их дээд сургууль

Ⅰ Тавигдах шаардлага

Ангилал	Боловсролын зэрэг
Солонгос хэлний бэлтгэл	Монгол улсад эсвэл гадаадад Ахлах сургуулиас дээш боловсролын зэрэг эзэмшсэн болон (удахгүй төгсөх гэж буй сурагч) үүнтэй дүйцэх хүн

Ⅱ Сургалтын төлөвлөгөө

Улирал	Хугацаа	Хичээлийн цаг	Бусад
2023-1-р улирал	2023. 3. 6.~5. 12. (10долоо хоног)	200цаг	· Бүх нийтийн амралт: 5. 5 · Хичээл нөхөх өдөр: 5. 15
амралт 5. 16.~6. 2			
2023-2-р улирал	2023. 6. 5.~8. 11. (10долоо хоног)	200цаг	· Бүх нийтийн амралт: 6. 1, 6. 6 · Хичээл нөхөх өдөр: 7. 25~7. 26
амралт 8. 14~9. 1			
2023-3-р улирал	2023. 9. 4.~11. 10. (10долоо хоног)	200цаг	· Бүх нийтийн амралт: 9. 28, 9. 29, 10. 2, 10. 9 · Хичээл нөхөх өдөр: 11. 13~11. 16
амралт 11. 17~11. 24			
2023-4-р улирал	2023. 11. 27.~2024. 2. 2. (10долоо хоног)	200цаг	· Бүх нийтийн амралт: 12. 25, 2024. 1. 1. · Хичээл нөхөх өдөр: 2024. 2. 5~2. 6

Ⅲ Элсэлтийн хариу танилцуулах

Ангилал	Материал шалгах	Ярилцлага
Солонгос хэлний бэлтгэл	Бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтууд бүтэн эсэх	Шууд ярилцлага болон онлайн ярилцлага

※**Бичиг баримтын шалгалт, ярилцлагын хариугаар голч дүн, санхүүгийн чадамж хангалтгүй гэж үзсэн тохиолдолд элсэлтэнд тэнцэхгүй болно.**

※**Элсэлтийн үйл явц**

Материал хураалгах → **Материал шалгах** → **Ярилцлага** → **Төлбөр төлөх** → **Визэнд орох** → **Хилээр нэвтрэх**

Ⅳ Бүрдүүлэх материал

○ Зайлшгүй хураалгах / △ Зөвхөн шаардлагатай тохиолдолд

No.	Ангилал	Мэдүүлэх	Тэмдэглэл
1	Элсэлтийн анкет	○	- Эх хувиар хураалгах - Маягтыг татаж авах (Олон улсын боловсролын төвийн мэдээллийн сан) - https://globalgate.kwu.ac.kr/index.do → [게시판] дарах → [공지사항] дарах → [외국인공지사항] дарах
2	Сурах төлөвлөгөө	○	
3	Сургалтын төлбөр төлөх төлөвлөгөө	○	
4	Хувийн мэдээлэл хэрэглэхийг зөвшөөрсөн өргөдөл	○	
5	Сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ болон дүнгийн тодорхойлолт	○	- Эх хувь болон орчуулсан хувилбар хураалгах - Дүнгийн тодорхойлолтонд асуудал байх тохиолдолд, сургуулийн тайлбар бичиг (Сургууль болон захиралын) эх хувиар хураалгах
6	Боловсролын гэрчилгээ	○	- Эх хувиар хураалгах - Шаардлага: хууль зүйн яамны удирдамжыг дагаж мөрдөнө, төгсөлтийн урьдчилсан гэрчилгээг хүлээн зөвшөөрөхгүй - Апостиль(Apostille)
7	Гадаад паспорт болон иргэний үнэмлэх	○	- Хуулбарыг хураалгах
8	Эцэг эхийн иргэний үнэмлэх канондсон болон орчуулсан байх	○	- Хуулбарыг хураалгах
9	Эцэг эхийн ажлын газрын тодорхойлолт болон орлогын тодорхойлолт	○	- Эх хувь болон орчуулсан хувилбарыг хамт хураалгах
10	Банкны баталгаа	○	- Эх хувь / эх хувийг элчин сайдын яаманд хураалгасан болон, дахиж гаргах боломжгүй бол банкнаас "гэрчилгээний хуулбар эсхийг нотлох тодорхойлолтыг эх хувиар хураалгах - D4виз : 9,000$-с дээш, - D2виз : 18,000$-с дээш элчин сайдын яаманд хураалгасан байгаа тохиолдолд хуулбарыг тушаах - Солонгост оршин суух визтэй (D4 визнээс бусад) тохиолдолд хураалгах шаардлагүй

11	Төрөл садангын лавлагаа (нотариатаар баталгаажуулсан хувилбар)	△	- Эцэг эхийн аль нэг тал дахин гэрлэсэн тохиолдол (бичиг баримт дээрх овог өөр тохиолдолд) заавал төрөл садангын лавлагааг хураалгана - Эцэг эх салсан тохиолдолд, гэр бүл цуцалсан лавлагааг эх хувиар хураалгах - Эцэг эх нас барсан тохиодолд нас барсны лавлагааг эх хувиар хураалгах
12	Цээж зураг	○	- 3 X 4cm **Цагаан фонтой гадаад паспортын зураг)**

※ Шаардлагатай тохиолдолд нэмэлт бичиг баримт шаардаж болно.

※ Бүх бичиг баримт нь дүрэм журмын дагуу эх хувиар хураалгах ёстой, гарцаагүй тохиолдолд хуулбарыг хураалгасан бол элсэж орсны дараа зайлшгүй эх хувийг хураалгана. (эх хувийг шалгасны дараа эргүүлж олгоно)

Ⅴ Сургалтын төлбөр болон тэтгэлэг

1. Сургалтын төлбөр

Ангилал	Элсэлтийн хураамж	Сургалтын төлбөр (1,200,000вон *4улирал)	Сурах бичиг (1улирал)	Гэнэтийн ослын даатгал (1жил)	Нийт
Мөнгөн дүн	50,000вон	4,800,000вон	63,000вон	110,000вон	5,023,000вон

※ Даатгалын үнийн дүн өөрчлөгдөж болзошгүй бөгөөд заавал хамрагдах шаардлагатай болно.

※ Хилээр нэвтэрсэн өдрөөс хойш бсарын дараагаас улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдаж сар болгон даатгал төлнө.

※ Даатгалын мөнгө төлөгдөөгүй тохиолдолд виз сунгах боломжгүй.

2. Тэтгэлэг

А. Сургуульд элсэж орсноос хойшхи эхний улиралын дүн 70 онооноос дээш тохиолдолд, дүнгийн амжилтын тэтгэлэг болох 200,000воныг нэг удаа олгоно.

Б. Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(Топик)-д тэнцсэн тохиолдолд топик онооны онцлох тэтгэлэг олгоно.

※ Тэтгэлэг нь 2022 оны үзүүлэлтээр байгаа бөгөөд дээр дурдсан агууллага нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөж болзошгүй.

Ⅵ Дотуур байр

Ангилал	Дотуур байрны төлбөр	Бусад
2хүний 1өрөө	1,008,000вон / 21долоо хоног	○ Хөнжил, дэрийг хувь хүн өөрөө бэлдэнэ - Сургуулиас авч болох ба хөнжил дэрний үнэ тусдаа болохыг анхаарна уу ○ Хоолны мөнгө дотуур байрны мөнгөнд багтаагүй болно. - Сургуулийн хоолны газраас тусад нь худалдаж авах: 1хоол 3,900вон~4,300вон
4хүний 1өрөө	609,000вон / 21долоо хоног	

※ Дотуур байрнаас тогтоосон дүрэм журам эсвэл амралтын үеэр оршин суух хугацаанаас хамаарч дотуур байрны үнийн дүнд өөрчлөлт орж болно.

Их Дээд Сургуульд гадаад оюутан элсүүлэх 2023оны танилцуулга



I Тавигдах шаардлага

Ангилал	Боловсролын байдал	
Иргэншил	Эцэг эх болон сурагч бүгд гадаад иргэн байх	
Боловсролын түвшин	Шинэ сурагч	Дотоод болон гадаадад ахлах сургуулиас дээш боловсрол эзэмшсэн сурагч болон удахгүй төгсөх гэж буй төгсөгч
	Шилжиж ирсэн сурагч (3-р курс)	Гадаад болон дотоодод 4 жилийн сургалттай их сургуульд 2-с дээш жил суралцсан эсвэл мэргэжлийн коллежид суралцаж төгссөн(удахгүй төгсөх) төгсөгч
Хэлний мэдлэг	1. Топик 3-р түвшингээс дээш түвшинтэй байх 2. Сургуулийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтанд 3-р түвшингээс дээш оноо авсан байх	

Ⅱ Бүртгэл авах анги

Салбар		Танхим	Шинэ элсэлгч	Шилжиж ирэх сурагч	Элсэгчдийн тоо
Хүмүүнлэгийн салбар	1	Нисэх агаарын тээврийн үйлчилгээний анги	○	○	○○ хүн
	2	Олон улсын англи хэлний боловсролын анги		○	
		Солонгос хэлний боловсролын анги		○	
		Олон улсын анги-Олон улсын англи хэлний боловсролын анги	○		
		Олон улсын анги-Солонгос хэлний боловсролын анги	○		
		Олон улсын анги-Бизнесийн удирдлага	○		
	3	Тулааны урлагын анги	○		
	4	Цагдаагын удирдлагын анги	○	○	
	5	Нийгэм халамжын анги	○	○	
	6	Сэтгэл судлалын анги	○	○	
Байгалийн шинжлэх ухааны салбар	7	Гоо зүйн шинжлэх ухааны анги	○	○	
	8	Эрүүл мэндийн удирдлагын анги	○	○	
	9	Хэл авиа зүйн эмчилгээний анги	○	○	
	10	Хүнс тэжээлийн анги	○	○	
	11	AI-техникийн анги	○		
Урлагын салбар	12	Дотор интерьер дизайны анги	○		
		Интерьер дизайны анги		○	
	13	Спортын анги	○		

Ⅲ Танхимын танилцуулга



Нисэх агаарын тээврийн үйлчилгээний анги
Department of Airline Services

- Зорилго: Агаарын тээвэр, зочид буудал, аялал жуулчлалын чиглэлээр үйлчилгээний ажилтан бэлтгэн гаргах
- [Агаарын тээвэр] Онгоцны үйлчлэгч, нисэх онгоцны буудлын удирдлага
  [Зочид буудал, аялал жуулчлал] Дотоод болон гадаадын зочид буудал, ресорт, аялалын компани зэрэг бизнесийн чиглэл

Олон улсын анги
International Studies

- [Заавал судлах] Эхний улиралд заавал судлах хичээлүүдийг судлаж дуусгасны дараа хоёрдугаар семестрээс эхлэн нарын мэргэжлийг сонгоно.
- [Олон улсын англи хэлний боловсролын анги] Хүүхдийн англи хэлний боловсролын мэргэжилтэн(3~12нас), Олон улсын англи хэлний боловсролын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
  ※TESOL(Олон улсын англи хэлний багшийн үнэмлэх), CETS-TESOL(Олон улсын хүүхдийн англи хэлний багшын үнэмлэх), Англи хэлний чиглүүлэгч багшын гэрчилгээ авах боломжтой
- [Солонгос хэлний боловсролын анги] Олон үндэстний харилцан ойлголцол, олон нийтийн манлайллыг бий болгож, солонгос хэл, соёлыг сурах.
  Даяаршилд хувь нэмрээ оруулах солонгос хэлний боловсролын мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх
- [Бизнесийн удирдлага] Дотоод болон гадаадын дэлхийн компаниудад шаардлагатай бизнесийн практик мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх
  Сургууль төгссөний дараах карьер: бүтээгдэхүүн төлөвлөгч, удирдлагын зөвлөх, олон нийтийн санал асуулгын агентлагт судлаач, шинжээч гэх мэт.





Тулааны урлагын анги
Department of Martial Arts and Security

- Зорилго: Хамгаалагч, хамгаалалтын мэргэжилтнүүд, тулааны урлагийн удирдагчдыг бэлтгэн гаргах
- Биеийн хүчний анхан шатны сургалт, тулааны урлагийн ур чадвар, аюулгүй байдлын мэдлэг, хамгаалалтын эрэл хайгуул гэх мэт практик сургалт.
  Аюулгүй байдал · аюулгүй байдлын мэргэжилтэн, тулааны урлагийн удирдагчийн сургалт

Цагдаагын удирдлагын анги
Department of Police Administration

- Зорилго: Эмэгтэй цагдаа, аюулгүй байдлын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
- Кэндо, жүдо, таеквондо, хапкидо зэрэгт зориулсан тулааны урлагийн заалтай
- Дадлага, ажил эрхэлж буй дээд үеийн эгч нараас зөвлөгөө авах, ажлын байрны ярилцлага



KWANGJU WOMEN'S UNIVERSITY



Нийгэм халамжын анги

Department of Social Welfare

- Зорилго: Ард түмний сайн сайхны төлөө хариуцлага хүлээдэг мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг бэлтгэн гаргах
- Нийгмийн халамжийн иж бүрэн төв, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, олон үндэстний халамж гэх мэт нийгмийн ажилтнаар тухайн салбарт шаардлагатай ажлын ур чадварыг дээшлүүлэх сургалтыг хэрэгжүүлэх

Сэтгэл судлалын анги

Department of Counseling and Psychology

- Зорилго: Тухайн салбарт шаардлагатай практик зөвлөгөө өгөх ур чадвар бүхий сэтгэл зүйч мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
- Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Олон соёлын төв, Залуучуудад зөвлөгөө өгөх төв, Архины зөвлөгөө өгөх төв, Эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв, Коллежийн зөвлөгөө өгөх төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зөвлөгөө өгөх төв, ганцаарчилсан зөвлөгөө өгөх төв, сэтгэл зүйн тест боловсруулах, боловсролын байгууллагад сэтгэл зүйч гэх мэт.





Гоо зүйн шинжлэх ухааны анги

Department of Beauty department

- Зорилго: Арьс, үс, нүүр будалт, маникюр, гоо сайхны салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
- Солонгос улсын анхны 4 жилийн сургалттай гоо сайхны мэргэжлээр бакалавр болон магистер, докторын сургалт явуулдаг сургууль
- Сургууль төгссөний дараах ажил мэргэжил:
  [Боловсрол] Гоо сайхан, гоо сайхны боловсролын байгууллагад багш
  [Ажлын байр] Гоо сайхны салон, арьс арчилгааны салон, маникюрын салон, Хуйх, үс уналтыг эмчлэх өрөө, хуримын дэлгүүр, гоо сайхны судлаач, гоо сайхны бүтээгдэхүүний брэнд менежер гэх мэт.

Эрүүл мэндийн удирдлагын анги

Department of Health and Public Administration

- Зорилго: Үндэсний эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эрүүл мэнд, эмнэлгийн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
- Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Эрүүл мэнд, эмнэлгийн мэдээллийн менежер, эмнэлгийн удирдах ажилтан, эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагын судлаач, эмнэлгийн зохицуулагч гэх мэт





Хэл авиа зүйн эмчилгээний анги
Department of Language Therapy

- Зорилго: Хэлний нөхөн сэргээх мэргэжилтнүүдийг дэмжих
- Хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдийн хэл ярианы бэрхшээлийг оношлох. Хэлний нөхөн сэргээх төрөлжсөн сургалтыг хэрэгжүүлэх

Хүнс тэжээлийн анги
Department of Food and Nutrition

- Зорилго: Хоол тэжээлийн мэргэжилтнүүд, хоол тэжээлийн багш (дунд сургуулийн), эрүүл ахуйн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
- Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Катерингийн үйлчилгээ, хоолны компани, хүнсний үйлчилгээний салбар, гарааны бизнес гэх мэт.





AI-техникийн анги
Department of AI Convergence

- Зорилго: Хиймэл оюун ухаан (AI) болон бодит мэдээллийн хэрэгсэл (AR, VR) -тай холбоотой практик ур чадвартай бүтээлч эмэгтэй мэргэжилтнүүд бэлтгэн гаргах
- Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Том өгөгдлийн шинжилгээний мэргэжилтэн, AR/VR агуулгын мэргэжилтэн, компьютер графикийн мэргэжилтэн

Дотоод интерьер дизайны анги / Интерьер дизайны анги
Department of Interior and Architecture Design / Department of Interior Design

- Зорилго: Барилгын дотоод орон зайн зохион бүтээгч, дотоод орон зайн менежер бэлтгэн гаргах
- Материал, өнгө, тавилга, гэрэлтүүлэг, практик дизайн, компьютерийн ур чадвар зэрэг интерьер дизайны олон төрлийн мэргэжлүүдийн талаархи мэдлэг олгоно.
- Жил бүр үндэсний загварын уралдаанд оролцох, авъяаслаг сайн дурын үйл ажиллагаанд оролцох, карьераа тасралтгүй хөгжүүлэх боломжтой.





Спортын анги
Department of Sports

- Зорилго: Эмэгтэй спортын багш, спортын салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах
- Сургууль төгссөний дараах ажил мэргэжил: Өдөр тутмын амьдралын спортын багш, иог · пилатесын багш, нөхөн сэргээх дасгалжуулагч, спортын маркетер гэх мэт.

Ⅳ Бүрдүүлэх бичиг баримтууд

○ Заавал хураалгах шаардлагатай △ Зөвхөн шаардлагатай сурагчид

	Ангилал	Шинэ	Шил жиж ирсэн	Тэмдэглэл
1	Элсэлтийн анкет	○	○	- Анкет татаж авах (Олон улсын боловсролын төвийн мэдээллийн сан) - https://globalgate.kwu.ac.kr/index.do → [게시판] дарах → [공지사항] дарах → [외국인공지사항] дарах
2	Сурах төлөвлөгөө	○	○	
3	Сургалтын төлбөр төлөх төлөвлөгөө	○	○	
4	Хувийн мэдээлэл хэрэглэхийг зөвшөөрсөн өргөдөл	○	○	
5	Сүүлд төгссөн сургуулийн диплом болон дүнгийн тодорхойлолт	○	○	- Эх хувь болон орчуулсан хувилбарыг хураалгах - Дүнгийн тодорхойлолтонд асуудал байгаа тохиолдолд, сургуулийн тайлбар бичиг (Сургууль болон захиралын) эх хувиар хураалгах
6	Сургуулийн тодорхойлолт	–	△	- Эх хувь болон орчуулсан хувилбарыг хураалгах
7	Боловсролын гэрчилгээ	○	○	- Эх хувиар хураалгах - Шаардлага: хууль зүйн яамны удирдамжыг дагаж мөрдөнө, төгсөлтийн урьдчилсан гэрчилгээг хүлээн зөвшөөрөхгүй - Апостиль(Apostille)
8	Гадаад паспорт болон иргэний үнэмлэх	○	○	- Хуулбарыг хураалгах
9	Эцэг эхийн иргэний үнэмлэхний хуулбар болон орчуулсан хуулбар	○	○	- Хуулбарыг хураалгах
10	Эцэг эхийн ажлын газрын тодорхойлолт болон орлогын тодорхойлолт	○	○	- Эх хувь болон орчуулсан хувилбарыг хураалгах
11	Банкны баталгаа	○	○	- Эх хувиар хураалгах (Солонгос улсад оршин сууж байгаа тохиолдолд Солонгос дансанд банкны баталгаа гаргах - D2виз : 18,000$-с дээш - Солонгост оршин суух визтэй (D4биш) тохиолдолд хураалгах шаардлаггүй
12	Төрөл садангын лавлагаа	△	△	- Эцэг эхийн аль нэг тал дахин гэрлэсэн тохиолдол (бичиг баримт дээрх овог өөр тохиолдолд) заавал төрөл садангын лавлагааг хураалгана - Эцэг эх салсан тохиолдолд гэр бүл салсан лавлагааг эх хувиар хураалгах - Эцэг эх нас барсан тохиодолд нас барсны лавлагааг эх хувиар хураалгах
13	Цээж зураг 2ш (өнгөт)	○	○	- 3 X 4cm (цагаан фонтой байх)
14	Солонгос хэлний түвшин тогтоох шалгалт	○	○	- Эх хувиар хураалгах
15	Гадаад иргэний үнэмлэхний хуулбар	△	△	- Хуулбарыг хураалгах (үнэмлэхний ард урд тал)

※ Тус сургуулийн хэлний бэлтгэлийг төгссөн төгсөгч Их дээд сургуульд элсэн орж буй тохиолдолд 9, 10, 12 дугаарыг хураалгахгүй байж болно.

Ⅴ Сонгон шалгаруулалтын танилцуулга

1. Сонгон шалгаруулалтын өдөр

Ангилал	Бүртгэх хугацаа	Сонгон шалгаруулалтын танилцуулга	Хариу зарлах хугацаа
Эхний улирал-1р шат	2022. 12. 1.~2022. 12. 23.	2022. 12. 26.~2023. 1. 6.	2023. 1. 16.
Эхний улирал-2р шат	2023. 1. 16.~2023. 1. 27.	2023. 1. 30.~2023. 2. 3.	2023. 2. 13.
Жилийн эцсийн-1р шат	2023. 6. 12.~2023. 6. 23.	2023. 6. 26.~2023. 7. 7.	2023. 7. 17.
Жилийн эцсийн-2р шат	2023. 7. 17.~2023. 7. 21.	2023. 7. 24.~2023. 7. 28.	2023. 8. 7.

2. Материал хянах: Элсэлтийн анкет, апостиль, диплом/сургуулийн тодорхойлолт, топик-н оноо зэргийг нийлүүлж дүгнэх

3. Элсэлтийн анкет татаж авах: https://globalgate.kwu.ac.kr/index.do→ [게시판] дарах → [공지사항] дарах → [외국인공지사항] дарах

Ⅵ Сургалтын төлбөр болон тэтгэлэг

1. Сургалтын төлбөр

Салбар	Танхимын нэр	Шинэ элсэгчдийн сургалтын төлбөр	Шилжиж ирсэн сурагчдын сургалтын төлбөр
Хүмүүнлэгийн салбар	Агаарын тээврийн үйлчилгээний анги	2,716,000	2,714,000
	Олон улсын англи хэлний боловсролын анги	-	2,714,000
	Солонгос хэлний боловсролын анги	-	2,714,000
	Олон улсын анги	2,716,000	-
	Тулааны урлагын анги	2,716,000	-
	Цагдаагын удирдлагын анги	2,716,000	2,714,000
	Нийгэм халамжын анги	2,716,000	2,714,000
	Сэтгэл судлалын анги	2,716,000	2,714,000
Байгалын шинжлэх ухааны салбар	Гоо зүйн шинжлэх ухааны анги	3,584,000	3,582,000
	Эрүүл мэндийн удирдлагын анги	3,213,000	3,211,000
	Хэл авиа зүйн эмчилгээний анги	3,213,000	3,211,000
	Хүнс тэжээлийн анги	3,213,000	3,211,000
	AI техникийн анги	3,213,000	-
Урлагын салбар	Дотоод интерьер дизайны анги Интерьер дизайны анги	3,213,000	3,211,000
	Спортын анги	3,213,000	-

※ 2022оны хичээлийн жилийн байдлаар заасан бөгөөд өөрчлөгдөж болно

2. Тэтгэлэг

Ангилал	Төрөл	Шаардлага	Түвшин	Тэтгэлэгийн хэмжээ
Баклавр	Шинэ оюутны тэтгэлэг	Баклаврт элсэж орохдоо TOPIK-ийн оноотой сурагч	TOPIK 3-р түвшингээс доош эсвэл KWU-TOPIK	Сургалтын төлбөрийн 30%
			TOPIK 3-р түвшин	Сургалтын төлбөрийн 35%
			TOPIK 4-р түвшин	Сургалтын төлбөрийн 50%
			TOPIK 5-р түвшин	Сургалтын төлбөрийн 60%
			TOPIK 6-р түвшин	Сургалтын төлбөрийн 70%
	Суралцаж буй оюутны тэтгэлэг	Дүнгийн тэтгэлэг (Өмнөх улиралын голч дүн 2.5-с дээш байх)	TOPIK 3-р түвшингээс доош	Сургалтын төлбөрийн 20%
			TOPIK 3-р түвшин	Сургалтын төлбөрийн 30%
			TOPIK 4-р түвшин	Сургалтын төлбөрийн 50%
			TOPIK 5-р түвшин	Сургалтын төлбөрийн 60%
			TOPIK 6-р түвшин	Сургалтын төлбөрийн 70%

※ Гадаад оюутны тэтгэлэг нь тогтоосон дүрэм журмаас хамааран өөрчлөгдөж болзошгүй.

3. Бусад дэмжлэг

А. Гэнэтийн ослын даатгал: 1жилийн даатгалын төлбөр 110,000вон

Б. Дотуур байр: Шинэ болон шилжиж ирсэн оюутан эхний улирал (16долоо хоног) дотуур байрны төлбөрөөс чөлөөлнө (4хүний 1өрөө, 464,000вон)

Гванжу Эмэгтэйчүүдийн Их сургуулийн Магистрийн ангид гадаад оюутан элсүүлэх 2023оны танилцуулга



Ⅰ Тавигдах шаардлага

Ангилал	Боловсролын байдал
Иргэншил	Эцэг эх болон сурагч бүгд гадаад иргэн байх
Боловсролын түвшин	[Нийтлэг] Дээр дурьдсан шаардлагад тэнцэх буюу түүнээс дээш албан ёсны эрдмийн зэрэгтэй хүн [Магистр] Эх орондоо болон гадаадад баклаврын зэрэг хамгаалсан болон 2023 оны 2-р сард бакалаврын зэрэг төгсөж байгаа хүн [Доктор] Эх орондоо болон гадаадад магистрын зэрэг хамгаалсан болон 2023 оны 2-р сард магистрын зэрэг төгсөж байгаа хүн
Хэлний мэдлэг	1. Топик 3-р түвшингээс дээш түвшинтэй элсэгч 2. Сургуулийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтанд 3-р түвшингээс дээш оноо авсан элсэгч

Ⅱ Бүртгэл авах анги

Зэрэг	Ангилал	Танхим	Хичээлийн жил	Хичээллэх хугацаа	Элсэлт авах тоо
Магистер	Ерөнхий мэргэжлийн ангиуд	• Гоо зүйн шинжлэх ухааны анги • Хүүхдийн англи хэлний боловсролын анги • Нисэхийн аялал жуулчлалын анги • Хүнс хоол тэжээлийн анги	2жил	өглөө	○○хүн
	Нийгмийн хөгжлийн ангиуд	• Нийгэм халамжын анги • Цагдаагын эрх зүйн анги	2жил	орой	○○хүн
Доктор	Ерөнхий мэргэжлийн ангиуд	• Гоо зүйн шинжлэх ухааны анги	2жил	өглөө	○○хүн

KWANGJU WOMEN'S UNIVERSITY

Ⅲ Сонгон шалгаруулалтын танилцуулга

1. Сонгон шалгаруулалтын хугацаа:
   Эхний хагас жилийн 1-р сарын дундуур
   Жилийн сүүлээр 6-р сарын дундуур

(Дэлгэрэнгүй мэдээллийг, магистрийн сургуулийн вэбсайтаас авна уу)

2. Материал хянах: Элсэлтийн анкет, апостиль, диплом/ сургуулийн тодорхойлолт, топик-н оноо болон төгсөлтийн үнэлгээг шалгана.

Ⅳ Сургалтын төлбөр болон тэтгэлэг

1. Сургалтын төлбөр

Ангилал	Салбар	Мэргэжлийн ангиуд	Сургалтын төлбөр	Бүртгэлийн хураамж	Нийт
Магистер	Ерөнхий мэргэжлийн ангиуд	Гоо зүйн шинжлэх ухааны анги	4,040,000вон	50,000вон	4,090,000вон
		Хүүхдийн англи хэлний боловсролын анги	3,390,000вон		3,440,000вон
		Нисэхийн аялал жуулчлалын анги	3,390,000вон		3,440,000вон
		Хүнс хоол тэжээлийн анги	4,040,000вон		4,090,000вон
	Нийгмийн хөгжлийн ангиуд	Нийгэм халамжын анги	3,129,000вон		3,179,000вон
		Цагдаагын хуулийн анги	3,129,000вон		3,179,000вон
Доктор	Ерөнхий мэргэжлийн анги	Гоо зүйн шинжлэх ухааны анги	5,139,000вон		5,189,000вон

2. Тэтгэлэг

Ангилал	Сургалтын төлбөр	Бусад
Топик 3р түвшин-с доош	Сургалтын төлбөрийн 40% хөнгөлнө	Зөвхөн сургуулийн Топик эсвэл улсын топикыг тооцно
Топик 4р түвшин-с дээш	Сургалтын төлбөрийн 50% хөнгөлнө	

Ⅴ Мэргэжлийн танилцуулга



Гоо зүйн шинжлэх ухааны магистр · докторын анги

Department of Beauty Science and Cosmetics

Гоо сайхны шинжлэх ухааны тэнхим нь системчилсэн онолын мэдлэг болон орчин үеийн гоо сайхны технологийн боловсрол олгодог. Онолын мэдлэг болон гоо сайхны технологийг нэгтгэн, үс, арьс, нүүр будалт, хумс гэх мэт гоо сайхны хүрээнд чадварлаг мэргэжилтэнг бэлтгэн гаргадаг. 2002онд Гоо сайхны шинжлэх ухааны баклаврын ангийг шинээр байгуулснаас хойш, 2007онд Гоо сайхны шинжлэх ухааны магистр, докторын ангийг байгуулж цэвэр гоо сайхны салбарын эрдмийн тогтолцоог бэхжүүлэх онцлог бүхий магистр баклаврын сургуулиар хүрээгээ тэлсэн.
Үс, гоо сайхан, арьс арчилгаа, нүүр будаг, гоо сайхны бүтээгдэхүүний анги зэргээс бүрдсэн сургалтын системийг дүүргэх бол, гоо сайхны байгууллага, үйлдвэртэй, хамтын ажиллагааны судалгаа болон төсөл хэрэгжүүлэх, гоо сайхны судалгааны хүрээлэн, клиник арьс судлалын хүрээлэнгээр дамжуулан гоо сайхантай холбоотой судалгаа, боловсролыг хийдэг. Энэ нь гоо сайхны мэдлэг, эрэл хайгуул хийх чадварыг хөгжүүлж, уран сэтгэмж бүтээлч байдлыг бий болгож, чадварлаг мэргэжилтнүүд болон удирдагчдыг бэлтгэн гаргадаг.

Хүүхдийн англи хэлний боловсролын магистрын анги

Department of Early Childhood Education



Хүүхдэд зориулсан англи хэлний боловсролын тэнхим нь сургуулийн өмнөх насны хүүхэд болон бага ангийн сурагчдад зориулсан англи хэлний сургалтын онол арга зүйг судалдаг салбар юм. Бид хэл, танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн хөгжлийн чухал үе шатанд байгаа хүүхдүүдийн онцлог, түвшинг ойлгож, англи хэлний боловсролыг олгох чадвартай хүүхдийн англи хэлний боловсролын мэргэжилтнүүдийг төрүүлж байна. Шинжлэх ухааны боловсролын хөтөлбөрөөр дамжуулан хүүхдийн англи хэлний боловсрол, заах журам, заах арга техник, төрөл бүрийн үйл ажиллагаа, практик сургалтын системд суурилсан сургалтын хөтөлбөртэй. Энэ нь багш нарыг төлөвшүүлэх, англи хэл заах, сурах чиг баримжаа олгох чадвартай хүүхдийн англи хэлний боловсролын мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах зорилготой юм.



Нисэхийн аялал жуулчлалын магистрын анги

Department of Airline and Tourism Development

Нисэх, аялал жуулчлалын танхим нь бүс нутгийн аялал жуулчлалын хөгжлийн талаарх ойлголтыг сэргээж, аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн аялал жуулчлалыг сэргээн хөгжүүлэхэд чиглэж байна. Энэ мэргэжлээр төгссөний дараа үндэсний болон орон нутгийн төрийн албан хаагчид болон хувийн судлаачид, зөвлөх компаниуд, инженерийн компаниуд, амралтын газар, амралт зугаалгын бизнес зэрэг аялал жуулчлалын чиглэлээр төрөл бүрийн салбарт орох боломжтой. Аялал жуулчлалын салбарт төлөвлөлт, үйл ажиллагааны менежментийн үүрэг гүйцэтгэх чадвартай мэргэжилтнүүдийг төлөвшүүлэхийн тулд аялал жуулчлалын хөгжлийн хичээлүүдийг зааж, судалгаа хийдэг.

KWANGJU WOMEN'S UNIVERSITY



Хүнс, хоол тэжээлийн тэнхмийн магистрын анги

Department of Food and Nutrition

Хүнс, хоол тэжээлийн тэнхим нь хүнсний үйлдвэрлэлийн оновчтой практик бүтээлч авъяас чадварыг хөгжүүлдэг, Fun & Creative (хөгжилтэй, бүтээлч) үйл ажиллагаа явуулдаг, хоол хүнс + хоол тэжээлийн чиглэлээр мэргэшсэн чадварлаг профессорууд болон, туршилт/дадлага хийх дэд бүтэцтэй тэнхим юм. Эрүүл ахуйч, хүнсний инженер, хүнсний үйлдвэрийн инженер, хөдөө аж ахуйн (ус, мал) хүнсний үйлдвэрлэлийн инженер, тогооч, хүүхдийн хоол хийх зааварлагч, хооллох дадал зуршлын дасгалжуулагч, солонгос хоолны цэс боловсруулагч, ази хоолны соёл тайлбарлагч, чихэр, нарийн боовны тогооч, франчайз эзэмшигч зэрэг тусгай зөвшөөрөл авах боломжтой.

Нийгэм халамжын магистрын анги

Department of Social Welfare



Нийгэм халамжийн анги нь хүн төрөлхтний аз жаргал, амьдралын чанарыг сайжруулахын тулд асуудалтай байгаа хувь хүн, гэр бүл, бүлэг, орон нутгийн иргэдэд шаардлагатай тусламжийг үзүүлэх мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргадаг. Түүнчлэн, нийгмийн халамжийн мэргэжилтний үүрэг, хариуцлагыг биелүүлэхэд чиглэсэн олон төрлийн сургалтын үйл явц, тухайлбал, мэргэжлийн туслалцааны үйл ажиллагааг явуулахад зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн дадлагын ур чадвар, нийгмийн халамжийн тогтолцоо, бодлогын онол, судалгааны арга зүй, олон нийтийн чиглэлээр практик сургалтууд гэх мэт сургалтууд явуулдаг. Үүний зэрэгцээ бид нийгмийн халамжийн онол, бодит сургалтаар нийгмийн халамжийн мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэдэг.



Цагдаагын эрх зүйн магистрын анги

Department of Police Law

Цагдаагийн эрх зүйн тэнхим нь эмэгтэй цагдаа, эмэгтэй цэрэг бэлтгэж, хээрийн сургалт болон практик ур чадварыг хослуулан төрийн албанд ороход чиглэсэн оюутнуудыг бэлтгэдэг. Цагдаагийн эрх зүйн төгсөлтийн сургууль нь цагдаагийн байгууллагын мэргэшсэн ажилтны өргөн хүрээний боловсролыг системтэй эзэмшиж, ард түмний амь нас, эд хөрөнгө, олон нийтийн аюулгүй байдал, хэв журмыг сахиулах хариуцлагатай, ирээдүйтэй, бүтээлч цагдааг бэлтгэн гаргах зорилготой.

※ Элсэгчийн анхаарах зүйлс

1. Элсэгчийн анхаарах зүйлс

А. Баримт материалыг хуурамчаар үйлдэх, дур мэдэн өөрчлөх зэрэг худал аргаар элсэн ороод асуудал илэрвэл элсэлтийг цуцлана.
Б. Энэхүү товч танилцуулганд бичигдээгүй зүйлийг уг сургуулийн дотоод дүрэм журмын дагуу дагаж мөрдөнө.
В. Хураалгасан бичиг баримт хангалтгүй, мөн элсэлтийн нөхцөл шаардлагад хүрээгүй тохиолд элсэлтэнд тэнцээгүйд тооцно.
Г. Хураалгасан бичиг баримтыг буцааж олгохгүй
- Бүх бичиг баримт нь дүрэм журмын дагуу эх хувиар хураалгах ёстой бөгөөд, гарцаагүй чухал байдлаас үүдэж хуулбарыг хураалгасан тохиолдолд эх хувийг оролцуулж эх хувийг харьцуулсанхувийг авах юм уу, элсэж орсны дараа зайлшгүй эх хувийг хураалгана (эх хувийг шалгасны дараа эргүүлж олгоно)

2. Элсэлтийн материал болон хувийн намтар бичиж бөглөхөд анхаарах зүйлс

А. Бүх баримт материалыг эх хувиар хураалгана. Солонгос хэл болон англи хэл дээр бичигдээгүй бол заавал орчуулсан хувийг хамт хураалгана.
Б. Тэмдэглэл хийсэн зүйлүүд бүгд ойлгомжтой гаргац сайтай бичиж бөглөсөн байх шаардлагатай. Хэрэв буруу бөглөсөн, орхигдсон, гаргагдхаргүй бичсэн зэргээс болж асуудал үүссэн тохиолдолд бидний зүгээс хариуцлага хүлээхгүй болно.
В. Хураалгасан баримтуудыг буцаан олгохгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт материал шаардана.
Г. Хураалгасан баримт материалыг засах цуцлах боломжгүй.

3. Хувийн мэдээлэл цуглуулах болон ашиглалт

А. Их сургуульд элсэн орох сонгон шалгаруулалтанд доор дурьдсан зорилгоор хувийн мэдээлэл цуглуулах болон ашиглагдаж болно.
Б. Элсэгчийн мэдээлэл: Нэр, хаяг, утасны дугаар, е-майл, оюутны бүртгэл, төгссөн (төгсөх)он, дансны мэдээлэл гэх мэт)
В. Асран хамгаалагчын мэдээлэл: Нэр, холбоо, хаяг, утасны дугаар гэх мэт
Г. Сургуулийн мэдээлэл: Төгссөн сургуулийн нэр
Д. Цуглуулсан мэдээллийг их сургуулийн зөвхөн элсэлт, тэтгэлэг, баклавр зэрэг хамгаалалт, статистик судалгаа болон сургуулиас тараагдах зааварчилгаа зэрэгт хэрэглэх болно. Энэхүү хувийн мэдээллийг хадгалах хугацаа дуусаад шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд бүр мөсөн шууд устгана.
Е. Дэлгэрэнгүйг агуулгыг элсэлтийн анкет дундаас ‘Хувийн мэдээлэл цуглуулах, нийлүүлэх’ маягтаас лавлаж харна уу.

※ Сургуулийн хотхоны газрын зураг



❶ 1-р байр: Mu-deng gwan
❷ 2-р байр: Hwang-ryong gwan
❸ 3-р байр: O-deung gwan
❹ 4-р байр: Information Communication Center
❺ Их сургуулиийн төв байр
❻ Номын сан
❼ Биеийн тамирын талбай
❽ Дотуур байр
❾ Спортын ордон



Холбоо барих

Хаяг (우편번호)62396, 광주광역시 광산구 광주여대길 22
광주여자대학교 국제교육원

Address (Zip code)62396, International Education Center,
22 Gwangjuyeodae-gil, Gwangsan-gu, Gwangju, KOREA

Email kwuiec@kwu.ac.kr
Tel +82-62-950-3931
+82-62-950-3576

광주여자대학교
KWANGJU WOMEN'S UNIVERSITY